# КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МЭДЭЭЛЭЛ

| № | Нэгж, хэлтэс, алба, тасаг | Албан тушаал | Албан тушаалын ангилал, зэрэглэл | Тайлбар /ажлын байрны чиг үүрэг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Захиргаа, санхүүгийн газар | Ажлын ажлын албаны дарга | Бусад | Кино урлагийг дэмжих тухай хууль тогтоомж, урт дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт кино урлагийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд Ажлын алба, Кино урлагийн зөвлөлийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг ажил олгогчийн өмнө хариуцна. |
| | | Захиргаа, санхүүгийн газрын дарга | Бусад | Ажлын албаны дүрэмд тусгагдсан газрын чиг үүргийг холбогдох хуулийн хүрээнд хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах, Зөвлөл бөгөөд ажлын албаны даргын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана. Ажлын албаны хүний нөөцийн бодлого, хэрэгжилтийн зохицуулалтыг хангаж ажиллах; Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хууль, дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих; |
| | | Ерөнхий нягтлан бодогч | Бусад | Ажлын албаны нягтлан бодох бүртгэлийг олон улсын бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд үнэн зөв хөтлөн явуулж холбогдох тайлан, балансыг хугацаанд нь гарган ажиллана. |
| | | Хүний нөөцийн менежер | Бусад | Кино урлагийн зөвлөлийн ажлын албаны төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, гүйцэтгэлийг хангуулах, байгууллагын хүний нөөцийн бодлогыг (ажилтан сонгон шалгаруулж авах, сургаж хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх г.м) боловсруулж хэрэгжүүлэх, хүний нөөцийн асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Гэрээ, хуулийн асуудал хариуцсан ажилтан | Бусад | Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хуулийн байгууллагад байгууллагыг төлөөлөн оролцох, үндсэн үйл ажиллагаатай холбоотой Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах болон бусад гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, газрын даргын ажилд дэмжлэг үзүүлэн ажиллана. |
| | | Үйлчлэгч | Бусад | Кино урлагийн зөвлөлийн ажлын албаны төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, гүйцэтгэлийг хангуулах, байгууллагын хүний нөөцийн бодлогыг (ажилтан сонгон шалгаруулж авах, сургаж хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх г.м) боловсруулж хэрэгжүүлэх, хүний нөөцийн асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, |
| 2 | Монгол кино дэмжих газар | Монгол кино дэмжих газрын дарга | Бусад | КУДтХ-ийн 12-13 дугаар зүйлд заасан КУДС-аас санхүүжилт, зээл олгох арга хэмжээг зохион байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангах, Кино урлагийг дэмжих сангийн цахим системийн хэвийн ажиллагааг хангах, КУДС-нд ирүүлсэн төслийг хүлээн авах, баримт бичгийн бүрдүүлбэрт хяналт тавих |
| | | Монголын кино уран бүтээлчдэд үзүүлэх эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн санхүүжилтийн ажилтан | Бусад | Кино урлагийг дэмжих тухай хууль, хууль даган батлагдсан журмын хэрэгжилтийг хангах, төсөл, арга хэмжээнээс хамааран эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилтийн баримт материалын бүрдэл хангасан эсэхэд хяналт тавих, Кино урлагийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулан ажиллана. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Кино урлагийн салбарын судалгаа, бүртгэл мэдээллийн ажилтан | Бусад | Кино урлагийн салбарын уран бүтээлчдийн нэгдсэн судалгааг төрөлжүүлэн гаргах, үйл ажиллагаа явуулж буй уран бүтээлийн нэгдэл, студи, продакшны мэдээллийг тогтмол шинэчлэх, өөрийн байгууллагын сайтад байршуулах, холбоотой тоон үзүүлэлтийг нэгтгэн гаргах, холбоотой бусад ажил арга хэмжээг хийж гүйцэтгэнэ. |
| | | Тусгай сангийн лавлагаа, мэдээлэл, судалгаа хариуцсан ажилтан | Бусад | Кино урлагийг дэмжих сангийн төсөл, арга хэмжээний бүртгэл мэдээллийг хөтлөх, түүнийг шинэчлэн баяжуулах, бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг тогтворжуулах, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг хуулийн этгээд, олон нийтэд нээлттэй мэдээллэх, шаардлагатай тооцоо судалгааг хийх, мэдээллүүдээр хангах, вэб сайтад байршуулах мэдээлэл бэлтгэх; |
| 3 | Олон улсын хамтын ажиллагааны газар | Олон улсын хамтын ажиллагааны газрын дарга | Бусад | Кино урлагийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гадаадын уран бүтээлчдийг Монгол улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийх боломжийг бүрдүүлэх, зөвшөөрөл олгох, кино бүтээх зардлын тодорхой хувийг буцаан олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах , Монгол кино бүтээл болон уран бүтээлчдийг олон улсад сурталчлан таниулах, Олон улсын кино наадмуудад үйл ажиллагааг сурталчлан таниулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэн ажиллана. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Кино зураг авалт хийх зөвшөөрлийн асуудал хариуцсан ажилтан | Бусад | Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын хуулийн этгээд дангаараа болон Монгол улсын хуулийн этгээдтэй хамтран Олон улсад түгээх зорилгоор кино бүтээх тохиолдолд зардлын тодорхой хувийг буцаан олгох үйл ажиллагааг зохион байгуулах, КУДт хуульд заасан эрх бүхий албан тушаалтан, Зөвлөлийн гишүүдэд буцаан олголтын хүсэлттэй холбоотой шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэн ажиллана. |
| | | Буцаан олголтын санхүүгийн асуудал хариуцсан ажилтан | Бусад | Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын хуулийн этгээд дангаараа болон Монгол улсын хуулийн этгээдтэй хамтран Олон улсад түгээх зорилгоор кино бүтээх тохиолдолд зардлын тодорхой хувийг буцаан олгох үйл ажиллагааг зохион байгуулах, КУДт хуульд заасан эрх бүхий албан тушаалтан, Зөвлөлийн гишүүдэд буцаан олголтын хүсэлттэй холбоотой шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэн ажиллана. |
| | | Байршлын үйлчилгээ, олон улсын хамтарсан кино урлагийг дэмжих, олон улсын харилцааны хөтөлбөрийн ажилтан | Бусад | Олон улсын Хамтын ажиллагааг өргөжүүлэх, хэлцлийн үндсэн дээр гадаад улсын иргэн, хуулийн этгээдтэй хамтран бүтээсэн кино болон бусад төсөл, арга хэмжээг хамтран зохион байгуулж, зураг авалт хийх боломжтой Байршлын мэдээлэл, сурталчилгааг хийж гүйцэтгэнэ. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Олон нийтийн асуудал хариуцсан газар | Олон нийтийн асуудал хариуцсан газрын дарга | Бусад | Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд түргэн шуурхай хүргэх, байгууллагын цахим хуудсыг хөтлөх, дээд газраас удирдлагад цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тайлагнах, байгууллагын даргын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана. |
| | | Кино түгээлтийн ангиллын асуудал хариуцсан ажилтан | Бусад | Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй кино театрууд, өргөн нэвтрүүлгийн болон кабелийн телевизээр түгээж буй киноны насны ангиллыг тогтоох, шалгуур үзүүлэлтийг боловсруулах, кино театрт түгээж буй кинонд Монгол киноны болон гадаад киноны эзлэх хувь, тоон үзүүлэлтийг тооцох, дата үүсгэх, кино түгээлттэй холбоотой мэдээ, мэдээллийг тогтсон хугацаанд гарган ажиллана. |
| | | Олон нийттэй харилцах, үнэлгээ түгээлтийн хөтөлбөрийн ажилтан | Бусад | Кино урлагийг дэмжих тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр болон өөрийн байгууллагын цахим хуудаснаа мэдээлэх, шаардлагатай мэдээ тайланг боловсруулах, нэгтгэх, тайлагнах, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг, оролцоотой ажиллана. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Дижитал хаб, цахим үйлчилгээний хөтөлбөрийн ажилтан | Бусад | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цахим орчны аюулгүй ажиллагаа бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах, дижитал хэрэгсэл, цахим технологи, хуудас хөгжүүлэх мөн платформуудыг түлхүү хэрэглэх, мэдээлэл хамгаалах үр дүнтэй аргыг сонгож хэрэглэх, стандартыг хэрэгжүүлэх, вэб баримтад нэвтрэх, түүнийг ашиглах журам боловсруулж хэрэгжүүлэх, Кино урлагийг дэмжих сангийн цахим системтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах. |